



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах
тухай

ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх заалт, ШУА-ийн дүрмийн 30 дугаар зүйлийг тус тус үндэслэн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. “ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ журам баталсантай холбогдуулан “Журам батлах тухай” ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ


ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Д.РЭГДЭЛ

Б.АВИД

ШУА-ийн Тэргүүлэгчдийн
2021 оны 01 дүгээр сарын 14-ний
өдрийн хурлын 02 тоот
тогтоолын хавсралт



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХАРЬЯА ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛЖ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Шинжлэх ухааны Академийн Эрх зүйн байдлын тухай” хуулийн 4 дүгээр зүйл, “Шинжлэх ухаан, технологийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, “Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн дүрэм”-ийн 29, 30 дугаар заалтыг хэрэгжүүлж, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлын сул орон тоог нөхөх зарчмаар захирлын албан тушаалд тавигдах шаардлагыг хамгийн сайн хангасан эрдэмтнийг чадахуйн зарчимд үндэслэн сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх харилцааг зохицуулна.

1.2. Тухайн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааг төр, засгийн бодлого, шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжлийн нийтлэг шаардлагад нийцүүлэн удирдан зохион байгуулах чадвар бүхий эрдэмтэн хүн захиралд нэрээ дэвшүүлнэ.

1.3. Захирлыг тухайн салбарын эрдэм шинжилгээний ажлын онцлог, шаардлагыг харгалзан олон нийтэд нээлттэй зарлан сонгон шалгаруулж томилно.

1.4. Захирал нь Төрийн албаны болон Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалт, Шинжлэх ухааны Академийн харьяа хүрээлэнгийн захирлын албан тушаалын нийтлэг тодорхойлолтын шаардлагыг хангасан байна.

Хоёр. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

2.1. ШУА-ийн Тэргүүлэгчдийн газраас захирлыг сонгон шалгаруулж томилох эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нэр, захиралд тавигдах үндсэн шаардлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд зарлана.

2.2. Энэхүү журмын 1.4-т дурьдсан шаардлагыг хангасан гэж үзсэн эрдэмтэн судлаачид нэрээ дэвшүүлж, дараах материалыг бүрдүүлэн зарлал нийтлэгдсэнээс хойш 15 хоногийн дотор ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт ирүүлнэ.

2.2.1. Төрийн албан хаагчийн анкет

2.2.2. бичгээр гаргасан хүсэлт

2.2.3. иргэний үнэмлэхний хуулбар, эх хувийн хамт

2.2.4. боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт

2.2.5. үйл ажиллагааны хөтөлбөр

2.2.6. нийгмийн даатгалын дэвтэр (хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, эх хувийн хамт

2.2.7. бүтээлийн жагсаалт

2.3. Захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах комиссыг академийн ерөнхийлөгчийн тушаалаар 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Комиссын бүрэлдэхүүнд төрийн холбогдох байгууллага болон шинжлэх ухаан технологийн салбарын мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оролцуулна.

2.4. Комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.4.1. Нэр дэвшигчдийн ирүүлсэн материал журмын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлан дүгнэх

2.4.2. Нэр дэвшигч захирлын албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж буй байдлыг үнэлэхдээ Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журмыг баримтална.

2.4.3. Захирлын албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг, монгол хэлний бичгийн чадвар, цахим орчин, компьютерийн хэрэглээний программ ашиглах чадварын шалгалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, шалгалт авах ажлыг зохион байгуулна.

2.4.4. Нэр дэвшигчийн дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, удирдан зохион байгуулах, манлайлах болон багаар ажиллах чадварын сорил шалгалтыг захирлыг сонгон шалгаруулах комисс авна.

2.4.5. Журмын 2.4.3, 2.4.4-д заасан шалгалтын нийт авбал зохих онооноос 60 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд сонгон шалгаруулалтын эхний шатанд тэнцсэнд тооцно.

2.4.6. Нэр дэвшигчийн гадаад хэлний мэдлэгийн түвшинг тухайн хэлний албан ёсны үнэлгээний баримтыг үндэслэн үнэлнэ.

2.4.7. Сонгон шалгаруулалтын эхний шатанд тэнцсэн нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр болон бусад мэдээллийг холбогдох хүрээлэнгийн эрдмийн хамт олонд танилцуулах, санал авах ажлыг комисс зохион байгуулна.

2.4.8. Эрдмийн хамт олон нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцээд дэмжих эсэх талаар нууц санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн материалыг ШУА-ийн ерөнхийлөгчийн нэр дээр ирүүлнэ. Нэг нэр дэвшигч байгаа тохиолдолд санал хураалтын дүнг ирүүлнэ.

Гурав. Захирлыг томилох, түүний бүрэн эрхийн хугацаа, хугацаанаас өмнө чөлөөлөх

3.1. Эрдмийн хамт олны саналыг харгалзан ШУА-ийн ерөнхийлөгч харьяа хүрээлэнгийн захирлыг томилох тухай тушаал гаргаж, академийн Тэргүүлэгчдэд мэдээлнэ.

3.2. Захирлыг томилохоос өмнө Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5-д заасан мэдүүлгийг холбогдох байгууллагаас авсан байна.

3.3. Томилогдсон захирал бүрэн эрхийнхээ хугацаанд хийж гүйцэтгэх ажлын гэрээг ШУА-ийн ерөнхийлөгчтэй байгуулна.

3.4. Захирлын бүрэн эрхийн хугацаа академийн ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаагаар тодорхойлогдоно.

3.5. Дараах тохиолдолд захирлыг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө чөлөөлөх шийдвэрийг ШУА-ийн ерөнхийлөгч гаргаж болно. Үүнд:

3.5.1. Ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн;

3.5.2. Өөрийн санаачилгаар чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

3.5.3. Эрүүл мэндийн шалтгаанаар.

--- о о 0 о о ---